

Газрын самаран жигнэмэг

Орц

- 8 хоолны халбага давсгүй масло
- $\frac{3}{4}$ аяга элсэн чихэр
- 1 дусал самарны ханд (ванилинаар орлуулж болно)
- 1 өндөг
- 1 $\frac{1}{4}$ аяга гурил
- $\frac{3}{4}$ аяга газрын самар
- 1 лимон

Заавар

1. Масло, элсэн чихрээ хольж хөвсгөр болтол хутгана. Дээр нь хольж хутгасан өндөг болон хандаа нэмж хутгана. Гурил, жижиглэсэн самар, лимоны шүүс дараа нь ахин нэмж зуурна.
2. Хуурай гурил асгасан ажлын талбайд сайтар нухаж хүнсний скочонд оруулан хөргөгчинд 1 цаг амраана.
3. 1 см орчим бөөрөнхий болон тасдсаны дараа хавтгайлан калькан цаас дэвссэн тавцан дээр хавтан дээр өрж шарах шүүгээнд 15 минут орчим бор шаргал болтол 180 градуст байлгана.

